



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

Сургалтад хамруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.7, Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус ТУШААХ нь:

1. Стандартчилал техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан тус албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Бадарчийн Эрдэнэчимэг, Худалдаа, үйлчилгээний асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Дамдинсүрэнгийн Эрдэнэцэцэг, мэргэжилтэн Чулууны Байгалмаа, Хоол, үйлдвэрлэл үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн Ягдайн Бадмаа, Инженерийн байгууламжийн хэлтсийн Тээвэр хөдөлгөөн зохион байгуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн Баасанжавын Мөнхзул нарыг Стандартчилал тохирлын үнэлгээний орон тооны бус шинжээч бэлтгэх сургалтад 2019 оны 02 дугаар сарын 13-наас 14-ний өдрийг дуустал хугацаанд хамруулсугай.

2. Дээрх албан хаагчдад дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.33 дахь заалтын дагуу сургалтад хамрагдсан хугацааны цалинг олгохыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР